



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/226


Улаанбаатар хот

Сургалтын зардал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/337 дугаар тушаал, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын "Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай" 2015 оны 97/56 дугаар хамтарсан тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Эрүүл мэндийн ажилтны 2019-2020 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, хяналтын тоо, сургалтын хөтөлбөрийн жагсаалт, эмнэлзүйн сургагч багшийн төлөвлөгөө, сургалтын зардал батлах тухай А/121 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүл мэнд, нийгмийн халамжийн яам хоорондын хамтран ажиллах Тохиролцоонд тусгагдсаны дагуу "Сөүл төсөл"-ийн хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдах эмнэл зүйн сургалтад суралцах 20 эмнэлгийн мэргэжилтний сургалтыг 2019 оны 05 дугаар сарын 06-наас 10-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.
2. Бэлтгэл сургалтад шаардагдах 405,000 /дөрвөн зуун таван мянга/ төгрөгийг энэ онд батлагдсан төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын зардлаас гаргахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирал /Д.Ганцэцэг/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080897